**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/149 Улаанбаатар хот

Хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, төрийн албаны тухай хуулийн 33.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014-2016 оны хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавихыг Захиргаа, удирдлагын газар /Б.Ган-Очир/-т даалгасугай.

3. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүр төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засгийн газар /Л.Нэргүй/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ЛХАГВАСҮРЭН

My documents:\TUSHAAL\2013 on/tuluvluguu.doc

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр олон гүйцэтгэгчийн 2014 оны ...04... дугаар сарын 08-ны өдрийн...А/149.. дугаар тушаалын хавсралт

**ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2014-2016 он/**

| **Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**(*тоо, чанар, хугацаа*)-**ийн хүрэх түвшин** | | | | **Хариуцах ажилтны нэр** |
|---|---|---|---|---|
| Гүйцэтгэх ажил | Гүйцэтгэх хугацаа | Суурь түвшин | Зорилтот түвшин | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1.1 Иргэний нисэхийн үндсэн мэргэжлийн /нисэгч, инженер техникийн ажилтан, нислэгийн удирдагч/ болон бусад мэргэжлийн ажилтныг өндөр хөгжилтэй, үндсэн англи хэлтэй улс оронд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад бэлтгэх | 2014-2016 он | Иргэний нисэхийн үндсэн мэргэжлээр нийт 97 оюутан суралцаж байна. | Иргэний нисэхийн үндсэн мэргэжлээр өндөр хөгжилтэй, үндсэн англи хэлтэй улс оронд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад суралцагсдын тоо нэмэгдсэн байна. | ЗУГ-ын дарга |
| 1.2 Бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчнийг олон улсын стандарт, шаардлага, өөрийн орны онцлог, эрх зүйн орчинд нийцүүлэн дадлагажуулах, ур чадварыг хадгалах, давтан сургалт болон дахин мэргэшүүлэх сургалтад хамруулах | 2014-2016 он | - | Бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчнийг олон улсын стандарт, шаардлага, өөрийн орны онцлог, эрх зүйн орчинд нийцүүлэн дадлагажуулж, ур чадварыг хадгалах, давтан сургалт болон дахин мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. | ЗУГ-ын дарга<br>НСТ-ийн захирал |
| 1.3 Train Air –ийн жинхэнэ гишүүн болох | 2014-2015 он | Бэлтгэл ажлыг хангаж байна. | Train Air –ийн жинхэнэ гишүүн болсон байна. | НСТ-ийн захирал |
| 1.4 Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшууллын механизм, нийгмийн хамгааллын асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн Иргэний нисэхийн | 2014-2015 он | - | Иргэний нисэхийн тухай хууль тогтоомжид тусгуулах санал, бэлтгэл ажлыг хангасан байна. | Тэргүүн дэд дарга<br>ЗУГ-ын дарга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| тухай хууль тогтоомжид тусгах | | | | |
| 1.5 Дотоодын сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, иргэний нисэхийн мэргэжлийн сургалтыг өөрийн оронд нутагшуулах | 2014-2016 он | Зарим мэргэжлийн сургалтыг өөрийн нөхцөл боломжоор ашиглан явуулж байна. | Өөрийн нөхцөл боломжоор ашиглан явуулж байгаа иргэний нисэхийн мэргэжлийн сургалтыг тоо нэмэгдсэн байна. | НСТ-ийн захирал |
| 1.6 Удирдлагын менежментийн чиглэлээр нэгжийн дарга нарын чадварыг нэмэгдүүлж, удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх | I улирал | - | Удирдлагын менежментийн чиглэлээр нэгжийн дарга нарын чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулан, удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлсэн байна. | Дэд дарга<br>ЗУГ-ын дарга |
| 1.7 Баг, хамт олны уур амьсгалыг сайжруулах, байгууллагын соёлыг хөгжүүлэх, төлөвшүүлэх | 2014-2015 он | - | Баг, хамт олны уур амьсгал сайжирч, байгууллагад зэрэг соёл төлөвшсөн байна. | Тэргүүн дэд дарга<br>ЗУГ-ын дарга |
| 1.8 Ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн үнэлгээний оновчтой тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх | 2014-2015 он | Судалгааны шатандаа байгаа. | Ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн үнэлгээний оновчтой болгон үр дүнгийн урамшууллалтай холбогдуулж тооцдог болгосон байна. | Тэргүүн дэд дарга<br>ЗУГ-ын дарга |
| 1.9 Хүнийг хөгжүүлэх, ажил, албан тушаалын төлөвлөлтийг сайжруулах, карьерийн зам, үе шат, тогтолцоог боловсронгуй болгох хэрэгжүүлэх | 2014-2016 он | - | Хүнийг хөгжүүлэх, ажил, албан тушаалын төлөвлөлтийг сайжруулж, карьерийн зам, үе шатны тогтолцоог боловсронгуй болгон сайжруулсан байна. | ЗУГ-ын дарга |
| 2.0 Ажилтнуудын 30 хувийг англи хэлний сайн мэдлэгтэй болгох /level 3-4/ | 2014-2016 он | - | Ажилтнуудын 30 хувийг англи хэлний сайн мэдлэгтэй болгосон байна. | НСТ-ийн захирал |
| 2.1 Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан батлуулж, түүний дагуу ажилтнуудын нийгмийн баталгаар хангах | 2014-2016 он | - | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, түүний дагуу ажилтнуудын нийгмийн баталгааг хангасан байна. | ЗУГ-ын дарга |
| 2.2 Open Sky –д нэгдэн орох чиглэлийн дагуу мэргэжлийн ажилтан бэлтгэх | 2014-2016 он | - | Open Sky –д нэгдэн орох чиглэлийн дагуу мэргэжлийн ажилтан бэлтгэсэн байна. | Тэргүүн дэд дарга<br>ЗУГ-ын дарга |
| 2.3 ИКАО -д өөрийн байгууллагын төлөөлөгч ажиллуулах бэлтгэл ажлын хүрээнд ажилтанг бэлтгэх | 2014-2016 он | - | Өөрийн байгууллагын төлөөлөгчийг бэлтгэсэн байна. | Дэд дарга<br>ЗУГ-ын дарга |